



**ХҮНС-ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.9 дэх хэсэг Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны “Журам шинэчлэн батлах тухай” 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдэд 2020 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/41 дүгээр тушаалын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд төрийн бус байгууллагыг төлөөлөн “Тактижент” ТББ-ын Ц.Дарханбатын ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн бодогдсон урамшууллыг хавсралтаар баталсугай.

2. Үнэлгээний хорооны гишүүн Ц.Дарханбатад хавсралтад заасны дагуу 1,073,865 /нэг сая далан гурван мянга найман зуун жаран тав/ төгрөгийн урамшуулал олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Цэрэнбанзад/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэлгээний хороо /Р.Дашгомбо/-т даалгасугай

ЗАХИРАЛ



Н.УУГАНБАЯР

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын
захирлын 2020 оны 04 сарын 15
өдрийн 4/06 тоот тушаалын
хавсралт

ТТБ8393 № 5443342

Тендерийн нэр	№	Худалдан авах ажиллагаа зохион байгуулах үйл ажиллагаа	Ажлын цаг
Үнэлгээний хорооны гишүүн Ц.Дарханбат Худалдан авах ажиллагааны шинэчилсэн хуулиар хичээл заасан			3
ХХТ/202012001/01	1	Үнэлгээний хорооны 1 дүгээр хурал тендерийн материал бэлтгэх ашиг сонирхол, мэдүүлэг бөглөж өгөх.	12
	2	Урилга хэвлүүлэх www.tender.gov.mn байршуулах, тендерийн материал хэвлэж бэлтгэх.	3
	3	Тендерийн нээлт	1
	4	Үнэлгээний хорооны 2 дүгээр хурал	1.5
	5	Багц -1 Багц-2 Багц-3д тендерийн материал ирүүлсэн аж ахуйн нэгжийн агуулах зоорь танилцсан.	16
	6	Тендерийн үнэлгээ хянан үзэх шат, 3 дүгээр хурал, захиалагчийн зөвлөмж	48
	7	Байгууллагад тендерийн мэдэгдэл бэлтгэх	4
ХХТ/202012001/02	1	Үнэлгээний хорооны 1 дүгээр хурал тендерийн материал бэлтгэх ашиг сонирхол, мэдүүлэг бөглөж өгөх.	10
	2	Урилга хэвлүүлэх www.tender.gov.mn байршуулах, тендерийн материал хэвлэж бэлтгэх.	2
	3	Тендерийн нээлт	1
	4	Үнэлгээний хорооны 2 дүгээр хурал	1
	5	Багц -1 Багц-2 тендерийн материал ирүүлсэн аж ахуйн нэгжийн агуулах зоорь танилцсан.	16
	6	Тендерийн үнэлгээ хянан үзэх шат, 3 дүгээр хурал, захиалагчийн зөвлөмж	42
	7	Байгууллагад тендерийн мэдэгдэл бэлтгэх	5
Харьцуулалтын тендер 5 ажил	1	Үнэлгээний хорооны 1 дүгээр хурал тендерийн материал бэлтгэх ашиг сонирхол, мэдүүлэг бөглөж өгөх.	16
	2	Урилга хэвлүүлэх www.tender.gov.mn байршуулах, тендерийн материал хэвлэж бэлтгэх.	5
	3	Тендерийн нээлт	1.5
	4	Үнэлгээний хорооны 2 дүгээр хурал	1
	5	Тендерийн үнэлгээ хянан үзэх шат, 3 дүгээр хурал, захиалагчийн зөвлөмж 13 хоног	38
	6	Байгууллагад тендерийн мэдэгдэл бэлтгэх	5

Харьцуулалтын тендер 4 ажилд дахин зарласан	1	Үнэлгээний хорооны 1 дүгээр хурал тендерийн материал бэлтгэх ашиг сонирхол, мэдүүлэг бөглөж өгөх.	8
	2	Урилга хэвлүүлэх www.tender.gov.mn байршуулах, тендерийн материал хэвлэж бэлтгэх.	3
	3	Тендерийн нээлт	1
	4	Үнэлгээний хорооны 2 дүгээр хурал	1
	5	Тендерийн үнэлгээ хянан үзэх шат, 3 дүгээр хурал, захиалагчийн зөвлөмж	16
	6	Байгууллагад тендерийн мэдэгдэл бэлтгэх	4
Нийт ажилласан цаг			265
Монгол улсын засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25ны өдрийн 472 дугаар тогтоолын Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай ТҮ-7 нэгдүгээр зэрэг 674306, 2020 оны ажлын цаг 166.4			4052.3197
Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам 3.8 Захиалагч үнэлгээний хороонд ажилласан төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлд ажилласан цагийг үндэслэн ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож болно.			1,073,865